

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

“ЭМИЙН НЭРСИЙН ДАЛАЙ” СУДАР ДАХЬ АМЬТНЫ ГАРАЛТАЙ
ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН СУДАЛГАА

Цэцэгдарь Т.¹, Наранзаяа Л.², Анхцацрал Л.², Улаан-Од Х.²,
Сумьяахорол Г.³, Буянт Б.¹

¹Өвөр монголын үндэстний их сургууль

²Ач Анагаах ухааны их сургууль,

³Эм зүйн шинжлэх ухааны их сургууль

Email: tsetsegdari.t@monos.mn

Abstract**THE STUDY REGARDING PHARMACEUTICAL RAW MATERIAL OF ANIMAL
DERIVED MEDICINE IN “OCEAN OF MEDICINE NAMES”**

Tsetsegdari T.¹, Naranzaya L.², Ankhtsatsral L.², Ulaan-Od Kh.²,
Sumiyakhhorol G.³, Baoyintu Bai.¹

¹Inner Mongolia University for Nationalities, ²Ach Medical University

³Mongolian University of Pharmaceutical Sciences

Email: Tsetsegdari.t@monos.mn

Introduction

The development of Mongolian Traditional Medicine has been closely related to the Indian Ayurvedic medicine in the beginning, and the history of Tibetan medicine since the late middle ages. Therefore, it was impossible to conduct a study without including the historical texts of Tibetan medicine within history of Mongolian Traditional medicine. The scientists from the Inner Mongolia Autonomous Region of the People's Republic of China included "Materia medica of Tara", "Materia medica of Manjushri", "Materia medica of Yuthog" in the traditional medicinal ancient scripture. However, in recent times, although it has been considered that the "Ocean of medicine names" scripture of Karmapa Rangjung Dorje (1284-1339), the 3rd incarnating lama of Buddhist Karmapa sect should be included in the ancient reference book of pharmacology of Traditional medicine, there is no study aimed to study the ancient medicine in detail. Due to that we aimed to study the ancient pharmacology reference book in detail.

Goal

We aimed to clarify the hidden meaning, science or use of the names of raw materials in the fauna of the "Ocean of medicine names".

Materials and Methods

We conducted the study by using manuscripts, primary source methods, checklist method, and analysis synthesis method. We have used following materials Ocean of medicine names and Beautiful eyed ornament.

Results

Karmapa Rangjung Dorje's " Ocean of medicine names" was a novel written in the form of a narrative of the properties of 768 medicinal raw materials divided into 11 groups. When these 11 groups were divided into plant, animal, and mineral raw materials, the percentage of each was determined as

following: plants 462 (60.2%), 130 (17%), 91, 127 (16.5%), 23 (3%), and 26 (3.3%) of these raw materials from plants, minerals, animals, raw materials, extracts and tincture, respectively.

Also, the fauna was divided into humans, large meat, meat products, bones, vital bones, horns, bile, feathers, hair, feces, oil, milk, yogurt, and others. We differentially counted them by 8 faunas of animals and identified 90 animals and 116 raw material types.

Conclusion: There are more than 1.5 million species of all kinds of animals in the world. Most of these are occupied by insects. Forests, mountains, steppes, deserts, oceans, rivers, farmlands, urban gardens, homes, and any part of the biosphere are bound to encounter animals.

Medicines of animal origin occupy a very important place in modern medicine. High biologically active hormones and enzymes are extracted from internal and external excretory glands of animals and used for treatment. Lungs, eyes, blood, and bile are valuable raw materials for medicine.

Key words: Ocean of medicine names, animal derived medicinal raw materials

Pp. 33-37, References 15

Оршил

Монголын уламжлалт анагаах ухаан 5000 гаруй жилийн түүхтэй бөгөөд өвөг монголчууд болон монголчуудын бүтээн бий болгосон оюун ухаан, эрдэм мэдлэгийн үнэт өвүүдийн нэг билээ. Энэхүү өв бидний өвөг дээдсийн сэтгэлгээний цар, нөр их хөдөлмөрийн үр шимээр цогцлон бүрдэж, өнгөрсөн зууны түүхэн шалгуурыг туулан өнөөг хүрч ирэхдээ хөгжин цэцэглэх, уруудан доройтох түмэн нугачааг даван туулж, тэжээхүй ухаан, монголчуудын эрүүл амьдрах ухааны бүхэл бүтэн тогтолцоог бий болгон хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсаар ирсэн [1, 2]. МУАУ-ы хөгжил эхэн үедээ Энэтхэгийн “Аюурвед”-ийн анагаах ухаантай, дунд үеийн сүүл хэсгээсээ хойш Төвөдийн анагаах ухааны түүхтэй нарийн шижмээр холбоотой хөгжиж иржээ. Иймээс МУАУ-ы түүхийн хүрээнд Төвөдийн анагаах ухааны түүхэн зохиолуудыг багтаан авч үзэхгүйгээр судлах бололцоогүй юм [3].

XXI зууны УАУ-ы хөгжлийн үндэс нь өмнөх үеийн монгол болон бусад орны эмч, эрдэмтдийн бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судруудыг уншиж судлах, уг сурвалжид байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтуудыг гүнзгийрүүлэн ойлгох, эмч, маарамбуудын гарын авлага, увдисын гүн утгыг онож тайлах нь нэн чухал байна. Үүнийг шийдвэрлэхэд чухал түлхэц өгөх судалгааны чиглэл нь УАУ-ы сурвалж судлал, эм, эмийн түүхий эд судлал бөгөөд

энэхүү чиглэлийн судалгааг улам боловсронгуй болгон хөгжүүлэх нь чухал асуудал юм [4].

БНХАУ-ын ӨМӨЗО-ны эрдэмтэн судлаачид УАУ-ы эм судлалын эртний тулгуур сударт “Дарь эхийн эмийн рүмбэ”, “Манзуширын эмийн рүмбэ”, “Ютогийн эмийн рүмбэ” зэрэг зохиолыг багтаан авч үздэг. Гэвч сүүлийн үед бурхны шашны Гармапа урсгалын 3 дугаар хамба лам болох Гармапа Ранжундоржийн “Эмийн Нэрсийн Далай” хэмээх судрыг УАУ-ы эм судлалын эртний тулгуур бичигт багтаах нь зүйтэй хэмээн үзэх болсон ч тусгайлан нарийн судалсан судалгааны бүтээл одоогоор хараахан байхгүй байна.

Мөн ургамлын гаралтай түүхий эдийн хувьд бусад түүхий эдээс хамгийн өргөн хэрэглэж байгаа хэдий ч 60-70 хувь нь халуун оронд ургадаг ургамлын түүхий эдийг импортоор авч уламжлалт жорд хэрэглэж байгаа бөгөөд амьтны болон эрдсийн гаралтай түүхий эдийг 100 хувь Монгол орны түүхий эд ашиглан үйлдвэрлэж байгаа боловч амьтны гаралтай түүхий эдийн судалгаа тун хомс хийгдсэн байгаа юм [5].

Иймд гагцхүү уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг амьтан болон эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн нэршил, тус эрдэм, хэрэглээг үнэн зөв тодорхойлох нь нэн чухал бөгөөд ингэж эс чадваас эмийн түүхий эдээ зөв таних, эм найрлагын чанар, эмчилгээний үр дүнг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх боломжгүй юм. Иймд урьд өмнө судлагдаж байгаагүй эмийн

судар доторх амьтны гаралтай эмийн түүхий эдийн нэрийг түүвэрлэн, ангилж тус бүрийн латин, төвөд нэр болон чадал хэрэглээг судлан тогтоохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго

“Эмийн нэрсийн далай” судрын амьтны аймаг дахь эмийн түүхий эдийн нэрийн далд утга, тус эрдэм буюу хэрэглээг тодруулан тайлбарлах

Зорилт:

1. “Эмийн нэрсийн далай” зохиолын амьтны аймгийн бүтэц, ерөнхий агуулга, онцлогийг тогтоох,
2. Судрын доторх амьтны аймгийн түүхий эдийн түүвэр хийн, задлан шинжилж, Тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” болон бусад эмийн судрын амьтны гаралтай түүхий эдийн нэршил, хэрэглээтэй харьцуулан тайлал, тайлбар хийх.

Судалгааны материал

Бид судалгааны гол материалаар ༄ | ལྷན་མིང་གྱུ་མཚོ། “Эмийн нэрсийн далай” [6], | མཛེས་མཚན་མིག་རྒྱན། “Үзэсгэлэнт нүдэн чимэг” [7], Лувсанчүлтэм “Эм таних ухаан” [8], Жамбалдорж “Монгол эмийг зөв таних толь” [9], Данзанпунцаг “Эмийн хиргүй болор эрх” [10], Лувсан “Монгол эмийн судлал” [11] зэрэг зохиолуудыг сонгож, судраа төвөд хэлнээс монгол хэлрүү орчуулахад Тэрбиш Л “Төвөд – Монгол иж бүрэн толь бичиг” [12], Галсан С. “Төвөд монгол эмнэлгийн толь” [13] бүтээлүүдийг ашиглалаа.

Судалгааны арга зүй

Эх бичиг, сурвалж бичгийн судлал: Судлахаар сонгож авсан асуудалтай холбоотой бүхий л ном зохиолуудыг олж цуглуулах тэднийг ангилах, уншиж судлан ихээхэн хэмжээний мэдээлэл, мэдлэг баримт сэлттэй болох тэмдэглэл хийхэд хэрэгтэй болдог. Түүнчлэн судалгаанд эрт цагийн маарамба, эмч, эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан сүм бум, судар ном, бэсрэг бүтээлүүд зэрэг өргөн хүрээний мэдээллийн эх сурвалжтай ажиллах үед ном зохиол сурвалж бичиг судлах аргыг ашиглана [7, 8, 9, 10, 11, 14, 15].

Магадлан жагсаах арга: Энэхүү аргаар сурвалж бичгийн доторх амьтны гаралтай эмийн түүхий эдийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд ашигласан.

Үр дүн

Гармапа Ранжүндоржийн “Эмийн нэрсийн далай” судрын төгсгөлд “Тэр мэт найман зуун арван гурван эмт ургамлыг бусдад туслах сэтгэлээр олон онол, олон увдис, олон зарлиг нугуудыг нэгэн зүгт хураангуйлж аршийн дамжлагыг даган сүүлд Ранжүндорж бээр найруулан бичсэн болно” хэмээсэн боловч нийт 11 аймгийг ялган нэг бүрчлэн тоолбол 768 эмийн түүхий эд байх бөгөөд үүнд улаан, цагаан, хар гэх мэт өнгөөр ялгасныг нэгээр тоолсон болно.

Үүнээс ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдийн тус бүрийнх нь хувийг тогтооход нийт 768 эмийн түүхий эдээс ургамал 462 (60.2%), эрдэс 130 (17%), амьтан 91, 127 түүхий эд (16.5%), шимийн эм 23 (3%), усан эм 26 (3.3%) байв. Амьтны аймагт хүнээс гарах эмийн түүхий эд ба адгууснаас гарах эмийн түүхий эдийг гаргасан байх бөгөөд дараах байдлаар ангилсан байв.

Хүн – 11, их мах – 4, махны зүйл – 43, яс – 4, шимт яс – 4, эвэр, цөс – 24, өд, үс – 10, баас – 12, тос, сүү, тараг -11, бусад – 4

Энэхүү ангилал нь амьтнаар биш түүхий эдээр ялгасан байх бөгөөд үүнийг бид “Үзэсгэлэнт нүдэн чимэг” бүтээлийн дагуу 8 аймагт хуваан нийт хэдэн амьтны хэдэн түүхий эд байгааг гаргаж ирэв. Энэхүү найман аймгаас гөрөөсний аймаг хамгийн их буюу 21 амьтан 23,6%, нүхэнд оршигчдын аймаг 17 амьтан 19,1%, хүнд эзлэгдэгчдийн аймаг 12 амьтан 13,4%, хүчээр идэгчдийн аймаг болон араатны аймаг тус бүр 9 амьтан 10.1%, хошуугаар малтагчийн аймаг 10 амьтан 11,2%, чийг усанд амьдрагчдын аймаг 7 амьтан 7,8%, савраар малтагчид 5 амьтан 5.6% тус тус эзэлж нийт 90 амьтны 116 түүхий эд байгааг олж тогтоов.

Амьтны гаралтай эмийн түүхий эдийн хэрэглээг тодруулсан үр дүнгээс жишээ болгон аймаг тус бүрээс нэг нэг амьтныг дараах байдлаар үзүүлэв.

Савраар малтагчид

Тогос: མེ་བྱུ་ (Pavo cristatus) Махаар нь хүйтэн өвчнийг арилгана. Хорын өвчтэй хүнд шүтүүлж болохгүй. Өдөөр нь үсний хорыг арилгана. Баасаар нь нян өвчинд тусална

“Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Тогосын махаар шар ба хорын өвчнийг дарна. Тогосын өд бол хор,

уушгины өгөрийг арилгана, тогосын зүрхний цусаар гараг өвчнийг дарна. Үүний өдөөр хумхын амны чимэг гэдэг.

Хошуугаар малтагчид

Тоть: *᠗ᠡᠰ* (*Polytelis alexandrae*) Махаар нь биеийг хөнгөрүүлж, хүч тамирын үүсгэнэ.

“Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Тотины зүрх бол хаан ад, солиорох, манарах, зүрх хатгалахыг дарна. Махаар нь биеийг хөнгөрүүлэн, ид хүчийг нэмэгдүүлнэ.

Гөрөөсний аймаг

Зэрлэг сарлаг: *ᠰᠢᠨᠭᠢᠨᠢᠨᠰ* (*Bos grunniens*) Мах, ясаар нь хийг арилгахын дээд. Цөсөөр нь хүйтэн өвчнийг арилгана. Эвэрээр шарх, чингаа, нүдний өвчинд тустай гэсэн байсан бол “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Сарлагийн бухын эврээр яр хатиг, ходоодны өвчнийг арилгана.

Араатны аймаг

Чоно: *ᠴᠢᠨᠢᠯᠤᠯᠤᠰ* (*Canis lupus*) Махаар нь эс шингэснийг арилгахын дээд. Баас нь адын өвчнийг арилгана гэсэн байсан бол “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Чонын хэлээр хэл хавдсаныг засна, ходоодоор илчийг үүсгэн, эс шингэснийг шингээнэ, баасаар хавдрыг дарна. Чонын унгасаар жин тавивал усан хаванд тустай.

Хүчээр идэгчдийн аймаг

Тас: *ᠠᠭᠦᠷᠢᠮᠠᠭ* (*Aegyrius monachus*) Махаар ад нугуудын засна. Өдөөр адын өвчинг арилгахад мэдэж үйлдээрэй. Баасаар ад, бэтгийг номхруулна гэсэн байдаг бол “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Тасын махаар илчийг үүсгэн ашигыг эвдэнэ. Тасын баас илчийг үүсгэн, бэтгийг эвдэж, хавдрыг хатаана. Тасын ходоодоор бэтгийг эвдэж, галын илчийг үүсгэнэ. Ясаар шээс хаагдсаныг арилгана.

Хүнд эзлэгчдийн аймаг

Адуу: *ᠶᠡᠬᠤᠰᠠᠪᠠᠯᠤᠰ* (*Equus caballus*) Махаар хүйтнийг арилгана. Цөс нь адын өвчинд тустай. Шинэ тосны үрэл нь хорын өвчнийг арилгана. Ногоон хомоол нь үе гишүүний өвчинд тусална. Сүүгээр хүйтэн өвчнийг арилгана.Таргаар бадганыг арилгана. Бяслэг болон аарцаар хүйтнийг арилгахын дээд гэсэн байдаг бол “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Махаар нь хүйтэн хийн өвчнийг арилгана. Морь, илжигний махны

шөл усан хаванд тустай, морины хулмасаар булчин урвахыг дарна. Морины баас хорхойг арилгах хий шараар бөөлжихийг тогтооно. Битүү туурайтны ясаар шар усыг арилгана. Зургаан хөхөлт азарганы тагнайн цус шарханд тустай. Хонь, морины цөс шарханд тустай. Морь, илжигний сүү халуун, исгэлэн, давслаг амттай тул уушгийг анагааж үе гишүүний хийг арилгана, гэвч мунхруулах үйлдэлтэй. Хоолойгоор нь дуу хаагдсаныг арилгах бөгөөд яруу эгшигтэй болгоно.

Нүхэнд оршигчдын аймаг

Тарвага: *ᠮᠠᠷᠮᠣᠲᠤ* (*Marmota bobak*) Цөсөөр шархны хийг арилгана. Махаар нь хүйтэн хийг арилгана гэсэн байдаг бол “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т тарваганы элгээр яс хагарсныг барилдуулна.

Чийг усанд амьдрагчдын аймаг

Хар галуу: *ᠰᠢᠬᠡᠷᠠᠭᠠᠳᠤ* (*Phalacrocoracidae*) Махаар ерөнхийдөө биеийг хөнгөрүүлж, хүч тамирын үүсгэнэ, шээс хаагдахыг арилгана. Сүүлний өд нь шээс хаагдахыг арилгана.

“Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т Хар галууны өд шээс хаагдахыг арилгана.

Хэлцэмж

Манай дэлхийд оршин буй бүх төрлийн амьтдын зүйл 1.5 сая гаруй болсон байна. Эдгээрийн ихэнхийг шавжийн аймагт хамаарагдагчид эзэлдэг. Ой мод, уул хад, хээр тал, говь элсэн цөл, далай тэнгис, гол мөрөн, тариалангийн талбай, хот цэцэрлэг, айлын орон сууц болон биосферийн аль ч хэсэгт ямар нэгэн амьтан заавал тохиолдоно. Амьтны ертөнцийн ашиг тус, хор холбогдол олон янзаар илэрдэг. Бас тэдний дунд улс, ардын аж ахуйд ихээхэн ашиг тустай амьтад ч олон бий. Хүн төрөлхтөн зэрлэг адгуусан амьтдыг барьж зөвхөн гэрийн мал болгон ашиг шимийг амьдрал ахуйдаа хэрэглэх болсон нь хэчнээн их ач холбогдолтойг дурдахад хангалттай. Мал аж ахуйгаас мах, сүү, тос, арьс шир, үс ноос зэрэг таваарын үнэт бүтээгдэхүүн гардгаас гадна булчирхай, элэг цөс, ходоод гэдэсний салст бүрхэвч, нүд, цус мэт эрхтнээр олон төрлийн эм бэлдмэл хийдэг юм.

Орчин үеийн анагаах ухаанд амьтны гаралтай эм ихээхэн чухал байр суурь эзэлж байдаг. Малын дотоод, гадаад шүүрлийн булчирхайнаас биологийн асар өндөр идэвхтэй гормон, фермент гарган авч эмчилгээнд хэрэглэж

байна. Мөн уушги, нүд, цус, цөс цөм эмийн үнэт түүхий эд юм [15].

Хүн хортой амьтны аюулаас айж эмээхийн зэрэгцээ, түүнийг ажиглан шинжилж тэдний ялгаруулах хорыг эм болгон ашиглах оролдлого хайж байсан нь зохих үр дүнгээ өгсөн билээ. Могой, зөгийн хорноос гарган авсан үнэт эмүүд цөм уламжлалт анагаах ухаанаас уламжлалтай. Дээр цагт үе мөчний өвчнийг зөгийд хатгуулан эмчилдэг байсан нь уг амьтны хороор олон төрлийн зовуурт өвчин анагааж болох үндсийг нээж олгосон юм.

Дүгнэлт:

1. Судалгааны явцад “Эмийн нэрийн далай” судрын бүтэц, ерөнхий агуулга, ямар онцлогтойг тодруулан амьтны гаралтай эмийн түүхий эдийг “Үзэсгэлэнт нүдэн чимэг” бүтээлийн дагуу 8 аймагт хуваан ангилсан.
2. Гармапа Ранжундоржийн “Эмийн нэрсийн далай” сударт амьтны гаралтай 116 эмийн түүхий эд байгааг тогтоов. Мөн амьтны гаралтай түүхий эдийн хэрэглээг Тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” судраас тодруулав. Сударт буй амьтны гаралтай түүхий эдүүдийн латин нэрийг оноохдоо олон улсын амьтдын өгөгдлийн сангууд (Avibase-The world Bird Database, GBIF-the Global Biodiversity Information Facility, Medicine traditions г.м), болон төвөд хэлээр бичигдсэн *ལྷན་ཁྱེ་འཇུགས་དཔེ* зэрэг сурвалжуудыг ашигласан болно. Ингэснээрээ энэхүү зохиолд буй амьтны эмийн далд утгын тайлбар, тайлал хийх, эм судлал, эм найрлагын хэрэглээг тодруулах боломжийг бий болгоод зогсохгүй уг судрыг уншиж судлах, уг номд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамбуудын гарын авлага, увдисын гүн утгыг онож ойлгох, уламжлалт анагаах ухааны мэдлэгийг ул суурьтай сурч, судлах боломжийг бүрдүүлэхэд бага ч болов хувь нэмэр үзүүлэх болов уу. Энэ нь цаашид уламжлалт анагаах ухааны эм судлал, эм түүхий эд судлал, уламжлалт анагаах ухааны практик хэрэглээг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг сургалтад хэрэглэх боломжийг бүрдүүлнэ хэмээн бид үзэж байна.

Түлхүүр үг: Гармапа Ранжундорж, Эмийн нэрсийн далай, амьтны гаралтай эмийн түүхий эд

Ном зүй

1. Сумъяахорол Г. Нэр нь үл мэдэгдэх өнгөт эмийн сударт буй амьтны гаралтай зарим эмийн хэрэглээг тодруулах нь, магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, 2022, х.17
2. Сумъяахорол Г. Нэр нь үл мэдэгдэх өнгөт эмийн сударт буй амьтны гаралтай зарим эмийн хэрэглээг тодруулах нь, магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, 2022, х.17
3. Болд Ш. Монголын Анагаах Ухааны түүх, 4 боть, УБ, 2013, х.49
4. Болд Ш. Монголын Анагаах Ухааны түүх, 4 боть, УБ, 2013, х.52
5. Сумъяахорол Г. Нэр нь үл мэдэгдэх өнгөт эмийн сударт буй амьтны гаралтай зарим эмийн хэрэглээг тодруулах нь, магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, 2022, х.18
6. Гармапа Ранжундорж. Эмийн нэрсийн далай, төвөд судар, он тодорхойгүй, х.216-221
7. Тойн Жамбалдорж. Үзэсгэлэнт нүдэн чимэг, модон барын төвөд судар,
8. Лувсанчүлтэм. Эм таних ухаан, Бээжин, Үндэстний хэвлэл, 1998, х.111-116
9. Жамбалдорж. Монгол эмийг зөв таних толь, Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаантехник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2015, х.305-366
10. Данзанпунцаг. Эмийн хиргүй болор эрх, Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2019, II хэвлэл, х.480-705
11. Лувсан. Монгол эмийн судлал, Бээжин, Үндэстний хэвлэл, 1986, х.546-620
12. Тэрбиш Л. Төвөд – Монгол иж бүрэн толь бичиг, Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК, 2019, х.125-166
13. Галсан С. Төвөд монгол эмнэлгийн толь, Хөх хот, 2008 он, ӨМАХХ, Х.56-137
14. Бүрнээ Д., Энхтөр Д. Төвөд монгол илт өгүүлэх нэрийн толь, 2003, х.453-465
15. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал, Улаанбаатар, Мөнхийн үсэг ХХК, 2014, х.14, 17, 240-243
16. Хайдав Ц. Ардын эмнэлэгт хэрэглэж байсан амьтны гаралтай эм, УБ, 1977, х.15

Танилцаж, нийтлэх санал өгсөн: Академич, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ч.Чимэдрагчаа